



# **ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН ХАМГААЛАЛТ**

**БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2019 ОН**

НАА 67  
ДАА 340  
Г-193

## **ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН ХАМГААЛАЛТ**

### **БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

#### **СУДАЛГААНЫ БАГ:**

Судлаач: Л.Галбаатар, Монголын Хуульчдын холбооны гишүүн,  
хуульч

Шүүмжлэгч: С.Цэрэндорж, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), өмгөөлөгч  
Б.Хишигсайхан, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын  
хөтөлбөрийн менежер

Энэхүү судалгааг ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэн нийтлэв.

© Л.Галбаатар, 2019 он

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-99978-803-9-0

## АГУУЛГА

ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
I. УДИРТГАЛ.....	6
1.1. Гэрч, хохирогчид учирч буй аюул занал.....	6
1.2. Судалгааны хамрах хүрээ.....	11
II. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	13
2.1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц дахь зохицуулалт.....	13
2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн зохицуулалт олон улсын гэрээ, конвенцод нийцсэн байдал.....	18
2.3. Бусад хууль тогтоомж дахь гэрч, хохирогчийн хамгаалалт ..	20
III. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХАД ОРОЛЦОГЧИД .....	34
3.1. Шүүгч, прокурор, мөрдөгчийн оролцоо.....	34
3.2. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн бие даасан байдал.....	38
IV. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	42
4.1. Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлал.....	43
4.2. Гэрч, хохирогчийн мэдээллийн бүрэн бүтэн байдал.....	49
4.3. Гэрч, хохирогчийн мэдээллийн хүртээмжтэй байдал.....	50
V. ДҮГНЭЛТ.....	52
VI. ЗӨВЛӨМЖ.....	56
VII. НОМ ЗҮЙ.....	58

## ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- График 1. Гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэрэг үйлдсэн хүний тоо, 2018-2019
- График 2. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо, 2014-2018
- График 3. Тахарын алба (хуучнаар), ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс хамгаалалтад авсан иргэний тоо, 2014-2018
- График 4. Хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн тоо, 2014-2018
- График 5. Тухайн жилд хамгаалах гэрч, хохирогчийн тооны төлөвлөгөө, 2014-2019
- График 6. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “урьдчилан сануулах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2014-2018
- График 7. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн “тодорхой үйлдлийг хязгаарлах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2017-2018
- График 8. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “биечилсэн хамгаалалт”-ын тоон үзүүлэлт, 2014-2018
- График 9. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2014-2018
- График 10. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “аюулгүй газарт түр байрлуулах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2014-2018
- Хүснэгт 1. Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх олон улсын зохицуулалтад дотоодын хуулийг нийцүүлсэн байдал
- Хүснэгт 2. Гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тойм
- Хүснэгт 3. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хүснэгт 4. Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад оролцогчид
- Хүснэгт 5. Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ
- Хүснэгт 6. Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн бие даасан байдал
- Хүснэгт 7. Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг задруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт

## НЭГ. УДИРТГАЛ

### 1.1. ГЭРЧ, ХОХИРОГЧИД УЧИРЧ БУЙ АЮУЛ ЗАНАЛ

Гэмт хэргийг илрүүлэх, нотлох, хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гэрч, хохирогч нь гол үүрэг гүйцэтгэдэг тул тэдний аюулгүй байдлыг хангах шаардлагатай. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлд зааснаар гэрч, хохирогчийн мэдүүлэг нь нотлох баримтын нэг төрөл юм. Гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр тэдэнд нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний улмаас гэрч, хохирогч мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх зэрэг үйлдэл гарч байгааг судлаачид тэмдэглэжээ.<sup>1</sup> Судлаачдын тэмдэглэснээр, олон улсын хэмжээнд дөрвөн гэрч тутмын нэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн мэдүүлгээс буцдаг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэрхшээл учирч, бодит үр дүнд сөргөөр нөлөөлдөг гэж үздэг.<sup>2</sup>


2018-2019 оны байдлаар шүүхээс гэрчид хууль бусаар нөлөөлөх (гэрчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэхээр ятгасан) 3 гэмт хэргийг, хохирогчид хууль бусаар нөлөөлөх (хохирогчийг худал мэдүүлэг өгүүлэх зорилгоор өөрт нь хүч хэрэглэсэн) 2 гэмт хэргийг тус тус хянан шийдвэрлэж, гэм буруутай этгээдүүдэд ял шийтгэл оногдуулсан байна.<sup>3</sup>

<sup>1</sup> Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 1 дэх хэсэг.

<sup>2</sup> Г.Баттулга. Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо ба олон улсын чиг хандлага (илтгэл). Улаанбаатар. 2016.06.10. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. 5 дахь тал

<sup>3</sup> Шүүхийн шийдвэрийн цахим сан. Зүйл, хэсэг: 21.5.1. <http://new.shuukh.mn/eruaanhan>

График 1. Гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэрэг үйлдсэн хүний тоо, 2018-2019




Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээхээр заасан бөгөөд Улсын Их Хурлаас 2013 оны 07 сарын 05-ны өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталсан. Мөн Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг, 2 дугаар хавсралтаар “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо жил ирэх бүр нэмэгдсээр байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар харахад, дунджаар нэг жилд 30 мянга гаруй иргэн гэмт хэргийн хохирогч болж байна.<sup>4</sup>

<sup>4</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, хүйс, насны ангилал, сумаар, жилээр [http://1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_2300\\_011V1](http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_011V1)

График 2. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо, 2014-2018



Үүнээс 2014-2018 онд Тахарын ерөнхий газар (2014-2016 онд) болон Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс (2016-2018 онд) нийт 262 хүнийг хамгаалалтад авсан байна.<sup>5</sup> Тодруулбал, дунджаар гэмт хэргийн улмаас хохирсон 1500 хүн тутмын нэгийг Цагдаагийн байгууллага хамгаалалтад авч ажиллажээ. Ийнхүү хамгаалалтад хамрагдсан иргэдийн хувьд ихэвчлэн дараах төрлийн гэмт хэргийн гэрч, хохирогч байна.<sup>6</sup> Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг;
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг.

2018 онд улсын хэмжээнд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг” 210, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” 9,134, “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” 621, “Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг” 714 гарчээ.<sup>7</sup> Тодруулбал гэрч, хохирогчийг хамгаалалтад авах

<sup>5</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан. Улаанбаатар. 2018 он, 13 дахь тал <http://nli.gov.mn/?p=4921>


<sup>6</sup> Ш.Шинэбаяр (ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад). “Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалж буй өнөөгийн практик, тулгарч буй хүндрэл бэрхшээл” (илтгэл). Улаанбаатар. 2019.06.11

<sup>7</sup> Цагдаагийн ерөнхий газар. Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ. <http://police.gov.mn/resource/policegovmn/File/2019/01/08/go8kd8smlvmred5n/2018.12%20sar%20medee%20Burtgegsen%20hereg.pdf>




шаардлагатай гэмт хэргийн тоо 10,679 байна. Энэ хэмжээгээр хамгаалах шаардлагатай гэрч, хохирогчийн тоог тооцож төлөвлөх шаардлагатай юм. Түүнчлэн, 2018 онд гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад улсын хэмжээнд 7,306 хохирогчийг хэрэг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагаас хамгаалалтад авсан байна.<sup>8</sup>

*График 3. Тахарын алба (хуучнаар), ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс хамгаалалтад авсан иргэний тоо, 2014-2018*



Харин хамгаалалтад авсан хохирогчийн тоо нь гэрчийн тооноос илүү байгаа нь гэмт хэргийн хохирогч дахин хохирох эрсдэлтэй байгааг харуулж байна.

*График 4. Хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн тоо, 2014-2018*



Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 7 дугаар тогтоолоор байгуулагдаж, 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4 дүгээр тогтоолын 3 дахь заалтын дагуу татан буугдсан Тахарын ерөнхий газрын зүгээс

<sup>8</sup> Цагдаагийн ерөнхий газар. Улсын хэмжээнд 2018 онд хохирогч иргэн, хуулийн этгээдийн статистик мэдээ. <http://police.gov.mn/resource/policegovmn/File/2019/01/08/z3p955sbs78g0hu8/2018.12%20sar%20medee%20Hohirogch.pdf>

гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад дараах хүндрэл гарч байсныг судлаачид тэмдэглэжээ. Үүнд:

- хэрэг бүртгэгч, мөрдөгчдийн ажлын ачаалал өндөр, гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх талаарх мэдлэг хангалттай биш;
- гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын тусгай нэгж, мэргэшсэн ажилтан байхгүй;
- шүүгч, прокуророос гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшинг хэрхэн тогтоох аргачлал, асуумж байхгүй;
- хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, техник хэрэгслийн болон бусад нөхцөл бүрдээгүй, төсөв хөрөнгө шийдвэрлэгдээгүй зэрэг.<sup>9</sup>

Мөн Тахарын албаны тухай хууль 2016 оны 07 сарын 21-ний өдөр хүчингүй болсонтой холбоотойгоор, Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах тусгайлсан чиг үүрэг цагдаагийн байгууллагад оногдож, Цагдаагийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтад Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс 2016 оны 08 сарын 11-нд орсон. Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс гэрч, хохирогчийг хамгаалахад дараах хүндрэл гарч буйг холбогдох албаны хүмүүс онцолсон байна.<sup>10,11</sup> Үүнд:

- үүрэг гүйцэтгэх техник хэрэгсэл, автомашин, ажлын байр, хүний нөөцийн асуудлууд шаардлага хангах хэмжээнд хүрсэн хэдий ч, хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэхээр байна;

<sup>9</sup> И.Даваажамьян. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал (илтгэл). Улаанбаатар. 2016.06.10. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. 37, 39 дэх тал

<sup>10</sup> “Өнөөдөр” сонин. “Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар: Иргэний амь нас эрүүл мэндийг хамгаалдаг учир хариуцлага маш өндөр”. 2019.02.21 <https://police.gov.mn/a/4261>

<sup>11</sup> Ш.Шинэбаяр (ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад). “Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалж буй өнөөгийн практик, тулгарч буй хүндрэл бэрхшээл” (илтгэл). Улаанбаатар. 2019.06.11

- гадаад улсаас гадаадын иргэн хохирогч иргэн хүлээн авч, аюулгүй байдлын арга хэмжээг эрсдэлгүй зохион байгуулахад алба хаагчид мэргэших шаардлагатай байна;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль боловсронгуй бус;
- гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайнгүй, төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг, оролцоо бага;
- гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны нэгдсэн мэдээллийн сан байхгүй.

Дээр дурдсан аюул занал, бэрхшээлийг шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч болох гэрч, хохирогчийн эрхийг хамгаалах талаар ахиц гаргах өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан гэж хууль санаачлагч онцлон тэмдэглэсэн байна.<sup>12</sup> Иймд 2017 оны 05 сарын 18-ны өдөр батлагдаж, 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуульд туссан гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтыг шинжлэн дүгнэж, тэрхүү зохицуулалтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, эрх бүхий албан тушаалтнууд хэрхэн хэрэглэх талаар санал дэвшүүлэх шаардлагатай байна.<sup>13</sup>

## 1.2. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгааны хүрээнд гэрч, хохирогчийг үр дүнтэй, бодитой хамгаалахтай холбоотойгоор дотоодын хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд хэрхэн уялдуулах, олон улсын сайн туршлагад нийцүүлэн хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмж гаргав. Мөн Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-т туссан гэрч, хохирогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилт хэрхэн хэрэгжиж буйд дүгнэлт хийв. Үүнээс гадна гэрч,

<sup>12</sup> Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн тухай танилцуулга. 4 дэх тал <http://forum.parliament.mn/medias/30f9dbb9-ccaa-4037-a016-eed5b87ad7f1.docx>

<sup>13</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталлаа 2017.05.18 <http://www.parliament.mn/n/4yoy>

хохилогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын байгууллага болон бусад улсын хэрэгжүүлж буй сайн туршлагыг судалж, Монгол Улсад тус асуудлаар анхаарах асуудлыг тодорхойллоо.

Энэ хүрээнд судалгааны дараах асуудал дэвшүүлж ажиллалаа.  
Үүнд:

- Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт олон улсын хэм хэмжээнд нийцсэн эсэх;
- Шүүгч, прокурор, мөрдөгч болон өмгөөлөгчийн зүгээс гэрч, хохирогчийг хамгаалахад хамтран ажиллах зохицуулалт, нөхцөл оновчтой эсэх;
- Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах тухай шийдвэр хэр тодорхой, хэрэгжих боломжтой байдаг эсэх;
- Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд ямар мэдээлэл нууцлахыг тодорхой болгох буюу нууцлах мэдээллийн жагсаалтыг нарийвчлан боловсруулах шаардлагатай эсэх.

Судалгааны зорилгыг хангах үүднээс баримт бичгийн судалгааны арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон харьцуулалтын арга, учир шалтгааныг тайлбарлах, статистикийн үр дүнг хэрэглэх, тохиолдол шинжлэх, ангилан системчлэх зэрэг аргыг хэрэглэв.

## **ХОЁР. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Олон улсын хэмжээнд гэрч, хохирогчийг хамгаалах талаар хэд хэдэн хэм хэмжээ бий. Тэрхүү олон улсын хэм хэмжээ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13 дугаар бүлгийн 13.1-13.7 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлоход ач холбогдолтой. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, баримт бичиг дэх гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтыг дараах хэсэгт танилцуулж байна.<sup>14</sup>

### **2.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ ДАХЬ ЗОХИЦУУЛАЛТ**

#### **1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц<sup>15</sup>**

Тус конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны 12 сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 06 сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 2000 оны 11 сарын 02-ны өдөр соёрхон баталж, 2002 оны 01 сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.<sup>16</sup> Конвенцын 13 дугаар зүйлд “Оролцогч улс түүний нутаг дэвсгэрт эрүүдэн шүүгдсэн хэмээн мэдүүлж буй этгээд эрх бүхий байгууллагад гомдол гаргах, хэргээ шуурхай, шударгаар хянан шалгуулах явдлыг хангана. Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна” гэж заасан.

<sup>14</sup> Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт гэрээний жагсаалт [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040#1485132523196-a01c7d09-78b5](http://www.mfa.gov.mn/?page_id=29040#1485132523196-a01c7d09-78b5)

<sup>15</sup> Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CAT.aspx>

<sup>16</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яам. “Олон улсын эрх зүйн баримт бичгүүд”. [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040](http://www.mfa.gov.mn/?page_id=29040)

## 2. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм<sup>17</sup>

Тус дүрмийг Ромын дипломат бага хурлаар 1998 оны 07 сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 07 сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 2002 оны 04 сарын 05-ны өдөр соёрхон баталж, 2002 оны 04 сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.<sup>18</sup> Дүрмийн 68 дугаар зүйлд “Хохирогч ба гэрчийн хамгаалалт болон шүүх хуралдаанд тэдгээрийн оролцоо”-ны талаар зохицуулсан билээ. Тодруулбал, 68 дугаар зүйлийн 1-6 дахь хэсэгт шүүх, прокурорын зүгээс гэрч, хохирогчийг хамгаалах дараах үүргийг тусгажээ. Үүнд:

1. Шүүх хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодын болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авна. Ингэхдээ Шүүх 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тодорхойлсон нас, хүйсийн хүчин зүйл болон эрүүл мэндийн байдал, түүнчлэн гэмт хэргийн шинж чанар болон зөвхөн үүгээр хязгаарлахгүйгээр гэмт хэрэг нь бэлгийн, хүйсийн буюу хүүхдийн хүчирхийллийг хамарсан нөхцөл байдал зэрэг холбогдох бүх хүчин зүйлийг харгалзан үзнэ. Прокурор тийм арга хэмжээг, ялангуяа эдгээр гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахдаа авч хэрэгжүүлнэ. Тийм арга хэмжээ нь яллагдагчийн эрхэд хохирол учруулах буюу түүнтэй зөрчилдөх ёсгүй, түүнчлэн шударга болон нэг талыг бариагүй шүүх хуралдаан явуулахад хохирол учруулахгүй.
2. 67 дугаар зүйлд дурдсан нээлттэй сонсох зарчмыг үл хэрэглэн Шүүхийн танхим хохирогчид болон гэрчүүд, яллагдагчийг хамгаалах зорилгоор шүүх хуралдааны аливаа хэсгийг хаалттай (in Camera) явуулах буюу нотлох баримтыг цахилгаан буюу өөр тусгай хэрэгслийн тусламжтайгаар гаргаж тавихыг зөвшөөрч болно. Ялангуяа тийм арга хэмжээг бэлгийн хүчирхийллийн золиос болсон хохирогч буюу гэрч нь хүүхэд байх тохиолдолд хэрэв Шүүх өөрөөр шийдээгүй бол бүх нөхцөл байдал, ялангуяа тухайн хохирогч буюу гэрчийн санаа бодлыг харгалзан авч хэрэгжүүлнэ.

<sup>17</sup> Rome Statute of the International Criminal Court [http://legal.un.org/icc/statute/99\\_corr/cstatute.htm](http://legal.un.org/icc/statute/99_corr/cstatute.htm)

<sup>18</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яам. “Олон улсын эрх зүйн баримт бичгүүд”. [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040](http://www.mfa.gov.mn/?page_id=29040)

3. Шүүх зохимжтой гэж үзсэн шүүх хуралдааны шатанд хэрэв тэдгээрийн хувийн ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд хохирогчийн санаа бодол болон болгоомжлолыг гаргаж тавих буюу хянан хэлэлцэхийг зөвшөөрөх бөгөөд энэ нь яллагдагчийн эрх болон шударга бөгөөд нэг талыг бариагүй шүүх хуралдаан хийхэд хохирол учруулахгүй байх тийм байдлаар хэрэгжинэ. Шүүх зөв гэж үзсэн тохиолдолд тийм санаа бодол болон болгоомжлолыг Дэгийн буюу нотолгооны журмын дагуу хохирогчийн хууль ёсны төлөөлөгч илэрхийлж болно.
4. Хохирогч болон гэрчүүдэд тусламж үзүүлэх хэсэг 43 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт дурдсан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, зөвлөгөө өгөх болон бусад тусламж үзүүлэх холбогдох арга хэмжээг Прокурор болон Шүүхэд зөвлөж болно.
5. Энэ дүрмийн дагуу нотлох баримт буюу мэдээллийг задруулах нь аливаа гэрч буюу түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулахаар бол Прокурор хэргийг сонсож эхлэхээс өмнө болсон аливаа байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор тийм нотлох баримт буюу мэдээллийг задруулахгүй байж болох бөгөөд үүний оронд тэдгээрийн хураангуйг танилцуулж болно. Дурдсан арга хэмжээ нь яллагдагчийн эрх, шударга, тал үл харах шүүх хуралдаан явуулахад хохирол учруулахгүй бөгөөд энэ зарчимд нийцэх ёстой.
6. Аливаа улс түүний албан хаагчид буюу төлөөлөгчдийг хамгаалах явдлыг хангах, түүнчлэн нууц буюу нарийн мэдээллийг хангахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авах хүсэлт гаргаж болно.

### **3. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол<sup>19</sup>**

Тус протоколыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 05 сарын 25-ны өдрийн А/RES/54/263 тогтоолоор баталж, 2002 оны 01 сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 2003 оны 06 сарын 27-ны өдөр соёрхон баталж, 2003 оны 07 сарын

<sup>19</sup> Optional Protocol to the Convention on the Rights of the Child on the involvement of children in armed conflict <http://www.un-documents.net/a54r263.htm>

27-ны өдрөөс мөрдөж байна.<sup>20</sup> Протоколын 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах байдлаар гэрч, хохирогчийг хамгаалах талаар заасан. Үүнд:

Оролцогч улсууд энэхүү Протоколоор хориглосон гэмт хэрэгт өртөж, хохирогч болсон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эрүүгийн шүүн таслах бүх ажиллагааны үед дор дурдсан арга замаар хамгаалах талаар зохих арга хэмжээ авна:

- (a) гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүүхдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний онцгой шаардлага, ялангуяа гэрч болохынх нь хувьд тэдгээрийн онцгой шаардлагыг хүлээн зөвшөөрсөн журам батлах;
- (b) хохирогч болсон хүүхдэд тэдний эрх, үүрэг болон шүүн таслах ажиллагааны агуулга, хугацаа болон явц, уг хэргийн талаарх шийдвэрийн тухай мэдээлэх;
- (c) шүүнтаслахажиллагааныявцадүндэснийхуультогтоомжийн байцаан шийтгэх хэм хэмжээний дагуу хохирогч хүүхдийн санаа бодол, шаардлага болон асуудлыг тэдгээрийн хувийн ашиг сонирхол хөндөгдсөн үед танилцуулж, хэлэлцүүлэх боломж олгох;
- (d) шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх;
- (e) шаардлагатай үед хохирогч хүүхдийн амь нас, нэр төрийг хамгаалах болон үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах.

#### **4. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц<sup>21</sup>**

Тус конвенцыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор 2000 оны 11 сарын 15-ны өдөр баталсан бөгөөд 2003 оны 09 сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд Монгол Улс 2008 оны 05 сарын 16-ны өдөр соёрхон баталж, 2008

<sup>20</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яам. “Олон улсын эрх зүйн баримт бичгүүд”. [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040](http://www.mfa.gov.mn/?page_id=29040)

<sup>21</sup> United Nations Convention against Transnational Organized Crime [https://www.unodc.org/pdf/crime/a\\_res\\_55/res5525e.pdf](https://www.unodc.org/pdf/crime/a_res_55/res5525e.pdf)



оны 06 сарын 27-ны өдрөөс мөрдөж байна.<sup>22</sup> Конвенцын 25 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцод тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж заасан.

### **5. “Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын тухай” тунхаглал<sup>23</sup>**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор батлагдсан тус тунхаглалын 4 дүгээр зүйлд гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах талаар заасан. Мөн тус тогтоолын хавсралт болох Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчмын 14-17 дахь хэсэгт хохирогчид үзүүлэх туслалцааны асуудлыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Хохирогч шаардлагатай материаллаг, эрүүл мэндийн, сэтгэл зүйн болон нийгмийн туслалцааг төрийн болон сайн дурын байгууллага, олон нийтэд түшиглэсэн байгууллага, уугуул иргэдийн туслалцаа авах ёстой.
- Хохирогч нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн болон бусад тусламжийн талаар мэдээлэл авах, тэдгээр үйлчилгээ, тусламжийг хүртэх ёстой.
- Цагдаа, шүүх, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний болон бусад албан тушаалтны хувьд хохирогчийн хэрэгцээ шаардлагад мэдрэмжтэй хандахын тулд зохих сургалтад хамрагдаж, шаардлагатай тусламжийг цаг тухайд нь үзүүлэх зохих удирдамж, заавартай байна.

<sup>22</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яам. “Олон улсын эрх зүйн баримт бичгүүд”. [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040](http://www.mfa.gov.mn/?page_id=29040)

<sup>23</sup> Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>

- Хохирогчид тусламж үзүүлэх, үйлчлэхдээ тийнхүү учирсан хохирлын шинж байдалд тохируулахад анхаарал хандуулах хэрэгтэй.

## 2.2. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА) ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦОД НИЙЦСЭН БАЙДАЛ

Энэхүү судалгааны 2.1 дэх хэсэгт дурдсан Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, баримт бичиг дэх гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтаар тогтоосон үндсэн шаардлагыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13 дугаар бүлгийн 13.1-13.7 дугаар зүйлд хэрхэн зохицуулсныг дараах хүснэгтээр харуулж байна.

### *Хүснэгт 1. Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх олон улсын зохицуулалтад дотоодын хуулийг нийцүүлсэн байдал*

Д/д	Олон улсын хэм хэмжээгээр тогтоосон шаардлага <sup>24</sup>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн зохицуулалт
1	гэрч, хохирогчийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авах	
2	заналхийлэл буй тохиолдолд гэрч, хохирогчийг хамгаалах	13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-1.4 дэх заалт, 2 дахь хэсгийн 2.1-2.4 дэх заалт, 3 дахь хэсгийн 3.1-3.3 дахь заалтад гэрч,
3	шүүх, прокурорын зүгээс хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодын болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авах	

үргэлжлэл ►

<sup>24</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц; Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм; Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол; Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц; Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчимд заасан шаардлага

4	шүүхийн танхим гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүх хуралдааны аливаа хэсгийг хаалттай явуулах буюу нотлох баримтыг цахилгаан буюу өөр тусгай хэрэгслийн тусламжтайгаар гаргаж тавихыг зөвшөөрөх, нотлох баримт буюу мэдээллийг задруулахгүй буюу тэдгээрийн хураангуйг танилцуулах	хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын нийт 11 арга хэмжээг хуульчилсан. <sup>25</sup>
5	зохих тохиолдолд гэрч, хохирогчийн хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээ авах	13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-3.3 дахь заалтад гэрч, хохирогчийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах бодит үндэслэл байгаа тухай прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх нэмэлт арга хэмжээ авч болохоор зохицуулсан.
6	шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх	Тусгайлан хохирогч хүүхдийг хамгаалах талаар заагаагүй ч 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2-т “нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох”-оор заасан. Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлд сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авах, 18 дугаар зүйлд хууль зүйн туслалцаа, сэтгэл зүйн туслалцаа, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэхээр зохицуулсан. <sup>26</sup>
7	хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах	

<sup>25</sup> 13.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн арга хэмжээ:

- 1.1. тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 1.2. биечилсэн хамгаалалтад авах;
- 1.3. мэдээллийн нууцлалыг хангах;
- 1.4. нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах.

*13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн арга хэмжээ*

- 2.1. нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
- 2.2. нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох;
- 2.3. шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох;
- 2.4. гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах.

*13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн арга хэмжээ*

- 3.1. гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах;
- 3.2. яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх;
- 3.3. шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсэж болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах.

<sup>26</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. “Төрийн мэдээлэл”. 2013 он, №30

Дээрх хүснэгтээс харахад Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн шаардлагыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуульд тодорхой хэмжээнд тусгажээ. Гэвч гэрч, хохирогчийн гэр бүлийн гишүүнээр хязгаарлалгүйгээр “бусад ойрын хүн” буюу хамтран амьдрагч, хадам эцэг, эх, хамт амьдарч байгаа бусад хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах зохих арга хэмжээ авах, хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг тараахаас сэргийлэх талаар тусгайлан зохицуулах шаардлагатай байна.

### **2.3. БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН ХАМГААЛАЛТ**

#### **2.3.1. Эрүүгийн хуулийн зохицуулалт**

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэрч, хохирогчийн болон түүний ойр дотнын хүнд нь хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулахаар сүрдүүлэх, эсхүл ятгах, шан харамж амлах, өгөх төдийгүй, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах нь гэмт хэрэг байхаар зохицуулсан.<sup>27</sup>

2018-2019 онд шүүхээс гэрчид хууль бусаар нөлөөлөх буюу гэрчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэхээр ятгасан 3 гэмт хэрэг, хохирогчид хууль бусаар нөлөөлөх буюу хохирогчийг худал мэдүүлэг өгүүлэх зорилгоор өөрт нь хүч хэрэглэсэн 2 гэмт

<sup>27</sup> Эрүүгийн хуулийн 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Гэрч, хохирогчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх зорилгоор өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан, шан харамж амласан, өгсөн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ”. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Энэ гэмт хэргийг хууль сахиулагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

хэргийг тус тус хянан шийдвэрлэж, гэм буруутай этгээдүүдэд ял шийтгэл оногдуулжээ.<sup>28</sup>

*Хүснэгт 2. Гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлөх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тойм*

№	Шүүхийн шийдвэр, огноо	Хэргийн товч	Ял шийтгэл
1	Дундговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 сарын 09-ний 15 дугаар шийтгэх тогтоол	Шүүгдэгч нь 2017 оны 04 сарын 08-ны өдөр Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд болсон зам тээврийн ослын талаар гэрчээр мэдүүлэг өгсөн насанд хүрээгүй гэрч Т.П-ийг зориуд худал мэдүүлэг өгүүлэхээр ятгаж, худал мэдүүлэг өгүүлсэн.	Шүүгдэгчийг 450,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн.
2	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 сарын 24-ний 120 дугаар шийтгэх тогтоол	Шүүгдэгч нь 2017 оны 09 сарын 25-ны өдөр Багануур дүүргийн ... дүгээр хороо, ... дугаар гудамжны ... тоот хашаанд оршин суух иргэн Д.Д-гийн гэрт өөрийн охин Б.М-р "хойд эцэг Н.Б-д удаа дараа хүчиндүүлсэн" гэж өргөдөл бичүүлж, худал мэдүүлэг өгүүлэх зорилгоор загнаж, зодох зэргээр хүч хэрэглэсний улмаас эрүүгийн ... дугаартай хэрэгт 2017 оны 09 сарын 25, 30-ны өдрүүдэд Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 2 давхрын мэдүүлэг авах өрөөнд, мөн 2017 оны 10 сарын 18-ны өдөр Төв аймгийн Цагдаагийн газрын мэдүүлэг авах өрөөнд насанд хүрээгүй хохирогч Б.М-ээр худал мэдүүлэг өгүүлсэн.	Шүүгдэгчийг 450,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн.
3	Төв аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 сарын 03-ны 262 дугаар шийтгэх тогтоол	Шүүгдэгч нь гэрчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэхээр ятгасан.	Шүүгдэгчийг 500,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн.
4	Хөвсгөл аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 сарын 22-ны 26 дугаар шийтгэх тогтоол	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 09 сарын 13-ны өдрийн яллагдагч М.Б-д холбогдох хэргийн анхан шатны шүүх хуралдаан дээр хохирогч Ч.Ж-ийг хулгайд алдсан малаасаа 15 хонийг буцааж олж авсан хэмээн зориуд худал мэдүүлэг өгүүлсэн	Шүүгдэгчийг 450,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн.

үргэлжлэл ►

<sup>28</sup> Шүүхийн шийдвэрийн цахим сан. Зүйл, хэсэг: 21.5.1. <http://new.shuukh.mn/eruanhan>

5 Хөвсгөл аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 20-ны 71 дүгээр шийтгэх тогтоол	Шүүгдэгч нь гэрч Д.Ч, С.М нарыг хууль бусаар ан агнасан гэмт хэргийнхээ талаар зохих байгууллагад мэдээлэхгүй байлгах зорилгоор тэдний дансанд тус бүр 1.000.000 төгрөг шилжүүлж гэрчид хууль бусаар нөлөөлсөн.	Шүүгдэгчийг 450,000 төгрөгөөр торгох ялаар шийтгэсэн.
--	---	---

Мөн Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг зориуд задруулж, нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан.

### 2.3.2. Төрийн болон албаны нууцын тухай хууль дахь зохицуулалт

Улсын Их Хурлаас 2016.12.01-ний өдөр баталж, 2017.09.01-ний өдрөөс үйлчилж буй Төрийн болон албаны нууцын тухай хууль, түүнийг дагалдаж гарсан Засгийн газрын тогтоолд “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл”-ийг төрийн нууцад хамааруулсан бөгөөд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцлахаар зохицуулсан.<sup>29</sup>

<sup>29</sup> Төрийн болон албаны нууцын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017 он, №11 “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл” нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4.п-д зааснаар тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд төрийн нууцад хамааруулах мэдээлэл бөгөөд 17 дугаар зүйлийн 17.4-т зааснаар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцална.

Мөн Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ын ю/хэсгийн 8-д, ё/ хэсгийн 40-д зааснаар “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээний хүрээнд хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл” нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, шүүх, прокурорын байгууллагын хэмжээнд болон хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбарын хэмжээнд “онц чухал нууц”-ын зэрэглэлтэй байх бөгөөд түүнийг байнга нууцална.

### **2.3.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль**

Улсын Их Хурлаас 2016 оны 12 сарын 22-ны өдөр баталж, 2017 оны 02 сарын 01-ний өдрөөс үйлчилж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлийн 7.1-д “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл өгсөн этгээд гэрч, хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлсэн этгээд, энэ хуульд заасан үүргээ гүйцэтгэж байгаа албан тушаалтан, ажилтныг айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгих, дарамт, шахалт үзүүлэх, буруутгах, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно” гэж заасан. Мөн тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д “Холбогдох албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хохирогч, гэрч, мэдээлэл өгсөн этгээдийн талаарх мэдээллийг задруулахыг хориглоно” гэж зохицуулсан. Ийнхүү мэдээлэл задруулсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлийн 2-т заасан “нууцалсан гэрчийг илчилж хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан” үйлдэлд хариуцлага хүлээлгэх үндэслэл болохоор байна.

### **2.3.4. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль**

Улсын Их Хурлаас 2012 оны 01 сарын 19-ний өдөр баталсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т зааснаар, хохирогч болон хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлж, таслан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдүүлэг өгсөн гэрч болон уг гэмт хэргийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэний аюулгүй байдлыг хангах зорилгоор мэдээллийн нууцлалыг хангахаар заасан.<sup>30</sup> Үүнд:

- гэрч, хохирогчийн өөрийн болон эцэг, эхийн нэр, оршин суугаа газрын хаяг, хувийн байдалтай нь холбоотой бусад мэдээллийг нууцлах;
- эдгээр мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түгээх, бусдад тараах, хохирогчийн нүүр царай, дуу хоолойг бусдад танигдахуйц байдлаар түгээхгүй байх;
- гэрч, хохирогч өөрөө бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд түүнийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, гэрч болсон тухай мэдээллийг гэр бүлийнх нь бусад гишүүнд мэдэгдэхгүй байх;
- мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч болон хэргийн бусад оролцогч гэрч, хохирогчийн хувийн байдлын тухай өөртөө ил болсон мэдээллийг бусдад тараахгүй байх;
- хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаягийг нууцлах.

### **2.3.5. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө**

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхтэй холбоотой хэд хэдэн зөвлөмж өгсөн. Үүний дагуу Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г баталсан.

30 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2012 он, №7



Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг батлагдсан орон тоондоо багтаан тодорхой нэг албан хаагчид хариуцуулан тогтвортой ажиллуулах арга хэмжээ авч, төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хууль зүйн яаманд хүргүүлж байхыг холбогдох сайд, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт даалгаж, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний комисст тус тус зөвлөсөн.

Энэхүү төлөвлөгөөнд зааснаар “Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах чиглэл”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэл”, “Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэл”, “Хүн худалдаалахтай тэмцэх чиглэл”-ээр тус тус гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан.

*Хүснэгт 3. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээ*

№	Зөвлөмж/зөвлөмжийн дугаар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага
Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр			
16	108.72. Эрүүдэн шүүсэн байж болзошгүй бүх хэргийг мөрдөн шалгах, хорих байрны болон шоронгийн барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчдод олгох эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх	- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зардал, хамгаалах тусгай байрны зардал болон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нөхөн төлбөрийн зардлыг улсын төсөвт тусгаж байх	- Хууль зүйн яам - Сангийн яам - Эрүүл мэнд, спортын яам - Тагнуулын ерөнхий газар - Цагдаагийн ерөнхий газар - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар - Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар

үргэлжлэл ►

26	108.126. Ял шийтгэлгүй үлдэх явдалтай тэмцэх, эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцөлийг хангах үүднээс эрүүдэн шүүсэн болон зүй бусаар харьцсан байж болзошгүй хэрэгт бие даасан, үр нөлөө бүхий мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх	- Гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг айлган сүрдүүлэх, дарамтлах, эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий дагнасан байгууллагын бие даасан, хөндлөнгийн хараат бус үйл ажиллагааг бэхжүүлэх	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар - Хууль сахиулахын их сургууль - Улсын дээд шүүх - Улсын ерөнхий прокурорын газар - Авлигатай тэмцэх газар - Хүний эрхийн Үндэсний комисс - Төрийн албаны зөвлөл
27	108.127. Бүх гэмт этгээдэд ял оногдуулах, хохирогчид цаг алдалгүй эрхээ сэргээлгэх, хамгаалалт авах нөхцөлийг бүрдүүлэх		

#### Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр

54	108.89. Гэр бүлийн хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүсийн хамгаалалтыг улам сайжруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудлаар Тусгай илтгэгч Монгол Улс хүлээн авах урилга хүргүүлэх	- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг батлуулах, хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалт хоорондын уялдааг сайжруулах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	- Хууль зүйн яам - Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам - Эрүүл мэнд, спортын яам - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам - Цагдаагийн ерөнхий газар - Хүүхдийн төлөө үндэсний газар - Хүний эрхийн Үндэсний комисс - Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз
----	--	---	--

үргэлжлэл ►


57	108.92. Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг одоогийн хуулиа үр нөлөөтэй хэрэгжүүлэх, алслагдсан газруудад хамгаалалтын байр барих зэргээр хохирогчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ бэхжүүлэх	- Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн гэрч, хохирогчийг түр хамгаалах байрыг орон нутагт бүсчилсэн хэлбэрээр байгуулах, тухайн байранд ажиллах сэтгэл зүйч болон нийгмийн ажилтны орон тоог нэмэх, холбогдох зардлыг төсөвт суулгах
58	108.93. Гэр бүлийн хүчирхийллийг эрүүгийн хэрэгт тооцох, хохирогчдын хамгаалалтыг сайжруулах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах зорилгоор Парламентаар хэлэлцэж байгаа гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийн төслийг батлах	- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээг аймгуудад үе шаттайгаар бий болгох
61	108.96. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үр нөлөө бүхий хамгаалалт авах, эрхээ сэргээлэх боломжийг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэм буруутныг яллах чадавхыг бэхжүүлэх, гэрлэлтийн хүчинг эрүүгийн хэрэгт тооцох	
<b>Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр</b>		
83	108.128. Насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх цогц тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэн бий болгох	Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах стандартыг бий болгох, хамгаалалтад байх үед нийгмийн болон эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох
		- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам - Хууль зүйн яам - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам - Хүүхдийн төлөө үндэсний газар - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд

Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр

89	108.116. Хууль сахиулах байгууллагын хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг яллах чадавхыг бэхжүүлэх, хохирогчдод үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх замаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах	- Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэргэшүүлэх сургалтыг шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагч, өмгөөлөгч болон хууль хяналтын байгууллагын бусад албан хаагчдад төлөвлөгөөтэйгөөр явуулах, хуульчдын албан ёсны сургалтад энэ чиглэлээрх сургалтыг хамруулах, хууль зүйн салбарт боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн агуулгад бие даасан бүлэг оруулах боломжийг судлан үзэх - Хамгаалах байрны хэвийн үйл ажиллагааг хангахуйц санхүү, тоног төхөөрөмж, бусад нөөцөөр хангах	- Хууль зүйн яам - Гадаад хэргийн яам - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам - Цагдаагийн ерөнхий газар - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар - Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар - Хууль сахиулахын их сургууль - Улсын дээд шүүх - Улсын ерөнхий прокурорын газар - Шүүхийн ерөнхий зөвлөл - Монголын Хуульчдын холбоо
94	108.121. Хүн худалдаалах хэргийн хохирогч, гэрч эрх зүйн туслалцаа, хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээ авах боломжоор баталгаатай хангагдах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай төсвийн, захиргааны болон эрх зүйн арга хэмжээнүүдийг авах		

Дээр дурдсан НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулалтын төсөвтэй байх нь чухал ач холбогдолтой байна. Тодруулбал, гэрч, хохирогчийг хамгаалахад байнгын тодорхой зардал (алба хаагчдын цалин, техник хэрэгслийн болон хамгаалалтын арга хэмжээний өртөг, зардал) гаргах шаардлагатай.

График 5. Тухайн жилд хамгаалах гэрч, хохирогчийн тооны төлөвлөгөө, 2014-2019



Гэвч Монгол Улсын тухайн оны төсвийн тухай хуулийн хавсралтад тусган төлөвлөсөн хамгаалах гэрч, хохирогчийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдээгүй, буурч 70-аас хэтрээгүй байна.<sup>31</sup> Харин хамгаалалт шаардлагатай гэрч, хохирогчийн тоо 7,306-10,679 байна.<sup>32</sup> Үүний улмаас, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээ нь төсвөөс хамаарч үр дүнгүй болох эрсдэлтэй болж байна.

<sup>31</sup> - Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” <https://www.legalinfo.mn/annex/details/8792?lawid=13781>

- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” <https://www.legalinfo.mn/annex/details/8091?lawid=12964>

- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” <https://www.legalinfo.mn/annex/details/7459?lawid=12249>

- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2016 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” <https://www.legalinfo.mn/annex/details/6959?lawid=11459>

- Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” <https://www.legalinfo.mn/annex/details/6640?lawid=10752>

- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2014 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” <https://www.legalinfo.mn/annex/details/6610?lawid=10398>

<sup>32</sup> Энэ талаар “1.1. Гэрч, хохирогчид учирч буй аюул занал” хэсэгт тайлбарласан.

### 2.3.6. Цагдаагийн байгууллагын дотоод хэм хэмжээ

Цагдаагийн байгууллагын хувьд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу төрийн захиргааны төв байгууллагуудаас батлан гаргасан хэм хэмжээг мөрдөж ажиллана.<sup>33</sup> Үүнээс гадна өөрийн үйл ажиллагааны журмын 511 дэх код буюу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар баталсан Гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтад гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах учирч болох аюулаас сэргийлэх, хамгаалах ажлын дэг горимыг тогтоох, хамгаалалтын арга хэмжээний мэдээллийн санг бүрдүүлэх,

<sup>33</sup> - Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан дараах тушаалыг мөрдөж байна. Үүнд:

- Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”;
- Хууль зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”;
- Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”;
- Хууль зүйн сайдын 2014 оны А/204 дүгээр тушаалаар батлагдсан “Биечилсэн хамгаалалтын журам”;
- Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2014 оны 356/А/182 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”;
- Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/29 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал”, “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний маягт, үнэлэх аргачлал”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны өдрийн А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх журам”, “Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээний үнэлгээний маягт”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/56/А/35 дугаар тушаалаар батлагдсан “Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам”, “Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтын бүртгэлийн маягт”;
- Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/22/А31 дугаар тушаалаар батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”.

ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.<sup>34</sup>

Энэхүү кодын 511.4-т заасны дагуу цагдаагийн албан хаагч гэрч, хохирогчийн аюулгүй байдал ба хувийн нууцыг хадгалахдаа дараах асуудалд анхаарч ажиллана:

- а) аюулгүй байдал, нууцлалыг хангахдаа байцаалт авах үед төдийгүй бусад ажиллагааны явцад хамгаалах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;
- б) хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах үүднээс түүний хаяг, ажил эрхлэлтийн байдал, шилжин суурьшилт зэрэг хувийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг нууцлах;
- в) шаардлагатай тохиолдолд хохирогч, гэрч болон түүний гэр бүлийн гишүүд, өмч хөрөнгийг хамгаалалтад авах;
- г) болзошгүй аюул тулгарсан тохиолдолд авч болох арга хэмжээний талаар мэдээлэл өгөх, туслалцаа үзүүлэх;
- д) хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээлэл өгөхдөө хохирогч, гэрчийг таньж мэдэж болохуйц мэдээлэл өгөхгүй байх;
- е) хохирогч, гэрчид хүч хэрэглэх, эд хөрөнгийг нь устгахаар заналхийлэх, хууль бусаар нөлөөлөх гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж буй тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд цагдаагийн алба нь гэмт этгээдийг илрүүлэх, гэмт үйлдлийг таслан зогсоох арга хэмжээг авах.

511.6.1-т заасны дагуу урьдчилан сануулах, гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх арга хэмжээнээс бусад хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэг нээнэ. 511.6.6-д заасны дагуу хяналтын хэрэгтэй дараах албан тушаалтан танилцана:

- а) Цагдаагийн төв байгууллагын дарга;
- б) Цагдаагийн төв байгууллагын тэргүүн дэд дарга;
- в) Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн дарга;

<sup>34</sup> Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (Mongolian National Police Agency Standart Operating Procedure). 4 дэх хэвлэл. Улаанбаатар, 2018 он. 665-698 дахь тал

- г) Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн тасгийн дарга;
- д) Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, эрүүгийн цагдаагийн тасгийн дарга.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20, 22 дугаар зүйлийн дагуу дээр дурдсан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэгтэй танилцах алба хаагчдын хувьд тагнуулын байгууллагаас явуулах аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцэх, төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан байх шаардлагатай. Гэвч аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэгтэй бүхэлд нь олон албан тушаалтан танилцахаар зохицуулсан нь зохимжгүй байна. Иймд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэгтэй танилцах хүрээ, хязгаарлалтыг тогтоох шаардлагатай. Тухайлбал, Цагдаагийн төв байгууллагын дарга болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын хувьд тоон мэдээ болон төсвийн зарцуулалт, алба хаагчдын хүртээмжийн түвшинд хяналтын хэрэгтэй танилцах; Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн болон тасгийн дарга; эрүүгийн цагдаагийн тасгийн даргын хувьд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, зардлыг шийдвэрлүүлэх хүрээнд танилцах нь зүйтэй байна.

“Биечилсэн хамгаалалтын арга хэмжээ” болон “Нэгбүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник, хэрэгслээр хангах хамгаалалтын арга хэмжээ”-ний үед хамгаалуулагчтай гэрээ байгуулах бөгөөд хамгаалуулагч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, хамгаалагч талаас өгсөн заавар, зөвлөмжтэй танилцаж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- хамгаалагч талд гэр бүл, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, найз нөхдийн талаарх мэдээллийг саадгүй гаргаж өгөх;
- хамгаалагч талд хаанаас, ямар аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг гаргаж өгөх, цаашид нөхцөл байдлыг тухай бүр мэдэгдэх;



- хамгаалагч талаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- нийтээр дагаж мөрдөх хууль, тогтоомж (аюулгүй ажиллагааны дүрэм, замын хөдөлгөөний дүрэм зэрэг)-ийг мөрдөж биелүүлэх;
- уулзах иргэд, оролцох арга хэмжээ, бусад нөхцөл байдлыг тусгасан мэдээлэл бүхий хөдөлгөөний чиглэлийг маягтын дагуу 24 цагаас доошгүй хугацааны өмнө, зайлшгүй шаардлагын улмаас хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд 3 цагийн өмнө маягтын дагуу хамгаалагч талд мэдэгдэх;
- хамгаалуулагч тухайн өдрийн хамгаалалт дууссанаас буюу 18 цагаас хойш гэр орон (аюулгүй газарт) болон хамгаалах байрнаас урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн гарах, түүнчлэн урьдчилан гарган өгсөн чиглэлээс бусад хөдөлгөөн үйлдэхгүй байх;
- хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг хамгаалах, бусдад задруулахгүй байх, баталгаа гаргах;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу сэтгэл зүйн туслалцаа авах.

Энд заасан хамгаалуулагчийн эрх, үүрэг нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор батлагдсан Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчимд заасан хамгаалуулагчид шаардлагатай материаллаг, эрүүл мэндийн, сэтгэл зүйн болон нийгмийн туслалцааг цаг тухайд нь үзүүлэх нөхцөлтэй нийцсэн байна.

## ГУРАВ. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХАД ОРОЛЦОГЧИД

### 3.1. ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧИЙН ОРОЛЦОО

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13 дугаар бүлэгт гэрч, хохирогчийг хамгаалахад шүүгч, прокурор, мөрдөгч болон өмгөөлөгч тус тусын оролцоотой бөгөөд харилцан уялдаатай ажиллахаар зохицуулжээ. Тодруулбал, гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг шүүхийн өмнөх шатанд болон шүүхийн шатанд хэрэгжүүлэхээр тус хуульд тусгасан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулж байна.

*Хүснэгт 4. Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад оролцогчид<sup>35</sup>*

Оролцогч	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат		Шүүхийн шат	
	Санал, хүсэлт гаргах	Шийдвэрлэх	Санал, хүсэлт гаргах	Шийдвэрлэх
Гэрч, хохирогч, өмгөөлөгч хүсэлт гаргах	Тийм	Прокурор	Тийм	Шүүгч
Мөрдөгч санал гаргах	Тийм		Үгүй	
Прокурор санал гаргах	Үгүй		Тийм	

Түүнчлэн шүүгч, прокурор, мөрдөгчийн зүгээс 1.2 дугаар хүснэгтэд дурдсан гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын нийт 11 арга хэмжээг харилцан адилгүй авахаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13 дугаар бүлэгт зохицуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулж байна.

<sup>35</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.1 дүгээр зүйл

### Хүснэгт 5. Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ<sup>36</sup>

Д/д	Арга хэмжээ	Шийдвэр гаргах этгээд	Арга хэмжээ авах этгээд
1	тодорхой үйлдлийг хязгаарлах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
2	биечилсэн хамгаалалтад авах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
3	мэдээллийн нууцлалыг хангах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
4	нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
5	нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
6	нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаарх мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
7	шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
8	гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах	прокурор, шүүгч	мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан
9	гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах	-	шүүгч
10	яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх	-	шүүгч

үргэлжлэл ►

<sup>36</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 13.1, 13.2 дугаар зүйл

11	шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсэж болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах	-	Шүүгч
12	гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргах	мөрдөгч	мөрдөгч

Дээр дурдсан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах тухай шийдвэрийн агуулгыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах байдлаар заасан байна:

- аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;
- аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;
- аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;
- аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

Эндээс харахад, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ тодорхой, хэрэгжих боломжтой байхуйц нөхцөлийг бүрэн тусгасан байна. Харин “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл” нь онц чухал нууцын зэрэглэлтэй, байнга нууцлах төрийн нууцад хамаарах тул үүнтэй холбоотой шийдвэрт дүгнэлт хийх боломжгүй байна.

Түүнчлэн гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд шүүгч, прокурор, мөрдөгч,

өмгөөлөгчийн мэдлэг, ур чадвар үндсэн нөхцөл болж байна. Гэрч, хохирогчийг хамгаалах эцсийн шийдвэрийг гаргах албан тушаалтан болох прокурор, шүүгчдийн хувьд гэрч, хохирогчийг хамгаалах асуудлаарх тусгайлсан сургалтад хамрагдаагүй байна. Тодруулбал, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2015-2019 оны шүүхийн сургалтын каталогт шүүгчдэд зориулсан гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой сургалтын хөтөлбөрийг бэлтгээгүй байна.<sup>37</sup> Мөн Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан “Сургалтын хөтөлбөр”-т тусгагдсан шинээр томилогдсон прокуроруудын анхан шатны сургалтад гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой сэдэв багтаагүй.<sup>38</sup> Иймд олон улсын болон үндэсний түвшинд гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой хамтарсан сургалт зохион байгуулах, харилцан туршлага хуваалцах нь чухал ач холбогдолтой.

Энд анхаарах зүйл бол шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгчийн зүгээс гэрч, хохирогчийг хамгаалах нөхцөл, шаардлага, үндэслэлийн талаар нэг мөр ойлголттой байх нь зүйтэй юм. Энэ хүрээнд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хуулийн зохицуулалтаар хязгаарлахгүйгээр гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болох аюулын эрсдэлийн түвшин тогтоох аргачлалтай болох, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах үүрэг, эрх бүхий албан тушаалтнууд нэг аргачлал, стандартыг мөрддөг болох шаардлагатай байна.<sup>39</sup>

<sup>37</sup> Шүүхийн сургалтын каталог-2019 <http://www.judcouncil.mn/main/8716--2019-.html>  
Шүүхийн сургалтын каталог-2018 <http://judinstitute.mn/catalog/site/catalog>  
Шүүхийн сургалтын каталог-2017 <http://www.judcouncil.mn/main/5239--2017-.html>  
Шүүхийн сургалтын каталог-2016 <http://www.judcouncil.mn/main/3505--2016-.html>  
Шүүхийн сургалтын каталог-2015 <http://www.judcouncil.mn/file/shuuhiiin%20surgaltin%20katalog.pdf>

<sup>38</sup> Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/03 тушаалаар “Сургалтын хөтөлбөр” батлагдсан. <http://www.prokuror.mn/a/2446>

<sup>39</sup> И.Даваажамьян. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал (илтгэл). Улаанбаатар. 2016.06.10. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл. 37, 40 дэх тал

### 3.2. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ НЭГЖИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ

Цагдаагийн байгууллагын гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндэс нэгэнт бүрдсэн байна.<sup>40</sup> Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь 2016 оны 08 сарын 11-нд цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад орсон.<sup>41</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 сарын 30-ны өдрийн А/136 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэл” батлагдсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь нийт 30 албан хаагчтай чиг үүргээ хэрэгжүүлж байна.<sup>42</sup>

Цагдаагийн албаны тухай хуулийн 85.2-т зааснаар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн албан хаагчдын үйл ажиллагаанд удирдах албан тушаалтан, бусад этгээд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг

<sup>40</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 10.1.8-д зааснаар гэрч, хохирогчийг хамгаалах нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд хамаарна. Мөн тус хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох хүрээнд “Цагдаагийн алба хаагч шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн хүн, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авна” гэж заасан. Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-т зааснаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх байгууллагын нэг нь цагдаагийн байгууллага юм. Мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т цагдаагийн байгууллага нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай нэгжтэй байхаар зохицуулсан.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т цагдаагийн байгууллага гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй гэж заасан. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Цагдаагийн алба хаагч шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн этгээд, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авна” гэж заасан.

<sup>41</sup> “Өнөөдөр” сонин. “Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар: Иргэний амь нас эрүүл мэндийг хамгаалдаг учир хариуцлага маш өндөр”. 2019.02.21 <https://police.gov.mn/a/4261>

<sup>42</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо. Улаанбаатар. 2018 он, 12-13 дахь тал <http://nli.gov.mn/?p=4964>

гүйцэтгэхийг шаардахыг хориглоно. Мөн Эрүүгийн хуулийн 4.6 дугаар зүйлд дээд шатны албан тушаалтны хууль бус тушаал, даалгаврыг биелүүлэхгүй байх, тийм тушаал, даалгавар өгөхгүй байх нөхцөлийг заасан. Энэ нь гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа бие даасан байхыг харуулж байна.

Энэхүү Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь Тахарын албатай харьцуулахад бие даасан байдал хэрхэн хангагдаж буйг дараах хүснэгтэд харуулав. Эндээс үзэхэд, Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь Тахарын албаны холбогдох нэгжтэй адил бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөлтэй байна.

*Хүснэгт 6. Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн бие даасан байдал*


№	Бие даасан байдлын нөхцөл	Тухайн нөхцөлийг хэрхэн хангаж буй байдал	
		Тахарын алба	ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс
1	Бүтэц, зохион байгуулалтыг тогтоох	Тойргийн тахарын албаны зохион байгуулалтын бүтцийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байна.	Цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар тогтооно. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байна.
2	Үйл ажиллагааны төсөв	Тахарын алба улсын төсвөөс санхүүжих бөгөөд төсөв нь түүний хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байна.	Цагдаагийн байгууллагын төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна.
3	Алба хаагчийн баталгаа	Тахарын албаны алба хаагчийн эрх, үүрэг, баталгаа болон хориглох зүйлийг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.	Иргэн, албан тушаалтан хэн боловч цагдаагийн алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно. Цагдаагийн алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хамгаална.

үргэлжлэл ►


4 Үйл ажиллагааны хяналт	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина. Шүүх, прокурорын байгууллага нь холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу хяналт тавина.	Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлаас бусад асуудлаар Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу хяналт тавина.
--------------------------	--	--

Тахарын ерөнхий газар (2014-2016 онд) болон Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс (2016-2018 онд) нийт 262 гэрч, хохирогч, иргэнийг (хамаарал бүхий этгээд, гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн хүн, шүүгч, прокурор) хамгаалалтад авч, нийт 179 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлжээ. Үүнд нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээний тоо ороогүй болно.<sup>43</sup>

*График 6. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “урьдчилан сануулах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2014-2018*



*График 7. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн “тодорхой үйлдлийг хязгаарлах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2017-2018*



<sup>43</sup> Ш.Шинэбаяр (ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад). “Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалж буй өнөөгийн практик, тулгарч буй хүндрэл бэрхшээл” (илтгэл). Улаанбаатар. 2019.06.11



График 8. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “биечилсэн хамгаалалт”-ын тоон үзүүлэлт, 2014-2018




График 9. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2014-2018





График 10. Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс хэрэгжүүлсэн “аюулгүй газарт түр байрлуулах” хамгаалалтын арга хэмжээний тоон үзүүлэлт, 2014-2018



Эндээс үзэхэд гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа Тахарын албанаас цагдаагийн байгууллагад шилжсэн нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний тоонд нөлөөлөөгүй байна. Тодруулбал, Тахарын албанаас хэрэгжүүлж байсан үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаас алдагдуулаагүй байна.

## ДӨРӨВ. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж заасан<sup>44</sup>. Мөн үүнтэй уялдаатайгаар Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-т гэрч, хохирогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зорилт болгон оруулжээ<sup>45</sup>.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “CIA гурвалжин”-гийн зарчмыг баримтлах шаардлагатай болохыг мэдээллийн аюулгүй байдлын судлаачид тэмдэглэсэн байдаг<sup>46</sup>. Энэ нь мэдээллийн нууцлал (*confidentiality*), бүрэн бүтэн байдал (*integrity*), хүртээмжтэй байдал (*availability*) харилцан тэнцвэртэй, гурвалжингийн тал мэт байх тухай үзэл санаа юм<sup>47</sup>.

Иймд Монгол Улсад гэрч, хохирогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг “CIA гурвалжин”-гийн зарчмын үүднээс тодорхойлж, цаашид анхаарах асуудлыг дэвшүүлэх нь чухал байна.

<sup>44</sup> Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 3.6 <http://legalinfo.mn/annex/details/3350?lawid=6163>

<sup>45</sup> Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, 2 дугаар хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” <http://legalinfo.mn/annex/?lawid=11387>

<sup>46</sup> Anthony Henderson. The CIA Triad: Confidentiality, Integrity, Availability. Panmore Institute. 2015.07 <http://panmore.com/the-cia-triad-confidentiality-integrity-availability>

<sup>47</sup> Энэ талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.2, 3.6.3, 3.6.4-т заасан. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. <http://legalinfo.mn/annex/details/3350?lawid=6163>

## 4.1. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үүднээс мэдээлэл, түүний бүрдэл хэсэгт хууль бусаар хандах, халдах, задруулахаас хамгаалснаар гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлал хангагдана.<sup>48</sup> Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нууцлалыг хамгаалах зарчмыг гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд баримтлахаар заасан. Мөн тус хуульд мэдээллийн нууцлалыг хангах нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний нэг хэлбэр байхаар зохицуулсан.<sup>49</sup> Энэ нь гэрч, хохирогчийн мэдээллийн сан үүсгэх, түүнийг гаднын хууль бус хандалтаас хамгаалахтай шууд холбоотой байх бөгөөд мэдээллийн нууцлалыг хангахад оролцогчдыг тодорхойлох, тэдгээрийн эрх, үүргийг уялдуулах шаардлагыг бий болгож байна.

### 1. Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах

Цагдаагийн байгууллагаас 2014-2018 онд мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээг нэг удаа авчээ.<sup>50</sup> Мэдээллийг нууцлахын тулд нууцлах мэдээлэл, түүний бүрдэл хэсгийг оновчтой тодорхойлох нь чухал юм. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан мэдээллийн нууцлалыг хангах зохицуулалтаас харахад нэн тэргүүнд нууцлах мэдээлэл, түүний бүрдэл хэсгийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна<sup>51</sup>. Үүнд:

- гэрч, хохирогчийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр
- оршин суугаа газрын хаяг
- өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө
- харилцах утасны дугаар
- тээврийн хэрэгслийн улсын дугаар.

<sup>48</sup> Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 3.6.3.1 <http://legalinfo.mn/annex/details/3350?lawid=6163>

<sup>49</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 3.1.2, 7.1.4. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2013 он, №30

<sup>50</sup> Ш.Шинэбаяр (ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад). “Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалж буй өнөөгийн практик, тулгарч буй хүндрэл бэрхшээл” (илтгэл). Улаанбаатар. 2019.06.11

<sup>51</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 11 дүгээр зүйл. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2013 он, №30

Гэхдээ хуульд нууцлах мэдээлэл, түүний бүрдэл хэсгийг дээрх жагсаалтаар хязгаарлаагүй бөгөөд бусад мэдээлэл байж болохоор байна. Энэ нь дээр дурдсанаас бусад нууцлах мэдээллийг тодорхойлох шаардлагыг бий болгож байна. Хуульд (5.2) шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг тус хуулийн зохицуулалтад хамааруулж болно гэж заасан. Мөн гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр (эхнэр), хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгохоор хуульчилсан байна.<sup>52</sup> Үүнээс гадна хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүнийг тус хуульд хамааруулж болохоор заасан. Иймд хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд дараах мэдээллийг нэгэн адил нууцлах шаардлага байна. Үүнд:

- гэрч, хохирогчийн болон тэдгээрийн нөхөр (эхнэр), хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охины овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр;
- гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүний овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр;
- тэдгээрийн оршин суугаа газар;
- тэдгээрийн өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө;
- тэдгээрийн харилцах утасны дугаар;
- тэдгээрийн тээврийн хэрэгслийн улсын дугаар.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 511 дэх код буюу Гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтын Маягт ЦБҮАЖ № 511.986 буюу “Хамгаалуулагчийн бүртгэл”-д дараах мэдээллийг тусгасан байна:

<sup>52</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 5 дугаар зүйл. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2013 он, №30

- ургийн овог, эцгийн (эхийн) нэр, өөрийн нэр
- регистрийн дугаар, төрсөн огноо, хүйс, нас
- төрсөн газар, иргэншил, үндэс угсаа, нийгмийн гарал, боловсрол, мэргэжил
- ажил эрхлэлтийн байдал, ам бүл, ял шийтгэлийн байдал, гэрийн хаяг.<sup>53</sup>

Харин АНУ-ын гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэдэг Маршалын албаны хувьд дээр дурдсанаас гадна гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийн дараах мэдээллийг нууцалдаг байна. Үүнд:

- иргэний харьяалал; нийгмийн даатгалын дугаар;
- төрсөн он, сар, өдөр; төрсөн газар.<sup>54</sup>

Үүнээс гадна АНУ-ын Маршалын алба өөрийн 2012-2018 оны стратегийн төлөвлөгөөндөө нууцлах мэдээллийн жагсаалтыг нарийвчлан боловсруулахаар тусгажээ.<sup>55</sup> Энэ нь цаг үеийн нөхцөл байдал, гэрч, хохирогчийн болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн онцлог зэргээс шалтгаалан нууцлах мэдээллийн жагсаалтыг тухай бүр шинэчлэн боловсруулж байх, тэрхүү жагсаалтыг өөрийг нь нууцалж байх нь зүйтэй болохыг харуулж байна.

## 2. Мэдээллийн нууцлалыг хангахад оролцогч

2014 онд “Хууль сахиулахуйн инноваци” олон улсын эрдэм шинжилгээний хурлын оролцогчид Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгууллагын харилцан ажиллагааг уялдуулах, гэрч, хохирогчийг хамгаалахад чиглэсэн дэд бүтцийг шийдвэрлэх, хүн хүчийг сургах,

<sup>53</sup> Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (Mongolian National Police Agency Standart Operating Procedure). 4 дэх хэвлэл. Улаанбаатар, 2018 он. 695 дахь тал

<sup>54</sup> U.S. Department of Justice - Certification of Identity <http://www.usmarshals.gov/foia/Forms/DOJ%20361.pdf>

<sup>55</sup> 6.4.1. Complete the identification and compilation of USMS critical information (Strategic Plan: 2012-2018, United States Marshals Service, U.S. Department of Justice) <http://www.usmarshals.gov/foia/strategic-plan.pdf>

чадавхжуулахад нягт хамтран ажиллахыг зөвлөсөн байдаг.<sup>56</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий үндсэн дөрвөн байгууллага болох цагдаа, мөрдөх алба, Авлигатай тэмцэх газар, тагнуулын байгууллага хамаарах бөгөөд бүгд өөр өөрийн эрх мэдлийн хүрээнд ажиллах ёстой.<sup>57</sup> Үүнээс гадна, шүүх, прокурорын байгууллага нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт заасны дагуу шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч нь гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах асуудлыг шийдвэрлэх үндсэн оролцогчид юм.

Эдгээр байгууллага нь гэрч, хохирогчийн болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн мэдээллийн нууцлалыг хангахад оролцогч болохын хувьд мэдээллийн нууцлалыг задруулсан этгээдийг олж тогтоох, түүнд хариуцлага хүлээлгэх зохицуулалт, журамтай байхыг НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодисын асуудал эрхэлсэн газраас улс орнуудын сайн туршлагыг судлан үзсэний үндсэн дээр зөвлөсөн байдаг.<sup>58</sup> Үүнийг бид анхаарч үзэх нь зүйтэй санагдаж байна.

---

<sup>56</sup> “Хууль сахиулахуйн инновац” олон улсын эрдэм шинжилгээний хурлын зөвлөмж. 9.1. 2014.10.08

- “Хууль сахиулахуй” сэтгүүл. 2014 №3, 4 (03, 04). 10 дахь тал <http://resource3.sod-onvision.com/lawuniversity/file/2015/9/996aps94qgy3dng2e8ghoqtneu/setguuli%2020140304.pdf>

- Хууль сахиулахын их сургуулийн цахим хуудас [www.leu.gov.mn/page/1055.shtm-l?sel=1585&subsel=2854](http://www.leu.gov.mn/page/1055.shtm-l?sel=1585&subsel=2854)

<sup>57</sup> Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйл.

<sup>58</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008 <http://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

*Хүснэгт 7. Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг задруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт*

№	Субъект	Туршлага, зохицуулалт	Эх сурвалж
1	АНУ <sup>59</sup>	Гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрт оролцогчийн мэдээллийн нууцыг зөвшөөрөлгүйгээр задруулсан этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх	Гэрчийн аюулгүй байдлын шинэтгэлийн хууль, 1984
2	Австрали <sup>60</sup>	Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны оролцогч этгээд тэдгээрийн нууцалсан буюу гэрч, хохирогчийг илчлэх эрсдэлтэй мэдээллийг задруулсан гэм буруутай бол түүнд хууль зүйн хариуцлага хүлээлгэх буюу тийм үйлдлийг гэмт хэрэгт тооцох.	Гэрчийг хамгаалах тухай хууль, 1994
3	Хонг Конг <sup>61</sup>	Гэрчийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хувийн мэдээлэл, оршин байгаа газар зэрэг мэдээллийг задруулбал эрүүгийн хариуцлага хүлээлгэх	Гэрчийг хамгаалах удирдамж, 2000
4	ХБНГУ <sup>62</sup>	Гэрч хамгаалах тусгай нэгж, бусад төрийн болон төрийн бус байгууллагын хамгаалалтад байгаа гэрчийн хувийн мэдээллийг нууцална. Ийнхүү нууцлах мэдээлэл нь гэрчийн мэдээллээр хязгаарлагдахгүй. Нууцалсан мэдээллийг прокурорын хүсэлтээр түүнд танилцуулж болно.	Эрсдэлд байгаа гэрчийг хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах тухай хууль, 2001
5	ӨАБНУ <sup>63</sup>	Гэрчийг хамгаалах хөтөлбөрт оролцож байгаа буюу хөтөлбөрийг хэрэгжүүлж буй этгээдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээллийг нийтлэх буюу задруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцох, тийнхүү задруулсан этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлох.	Гэрчийг хамгаалах тухай 112 дугаар хууль, 1998

үргэлжлэл ►

<sup>59</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.8 <http://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

<sup>60</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.9

<sup>61</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.11

<sup>62</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.12

<sup>63</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving

6	ИБУИНВУ <sup>64</sup>  Хамгаалагдсан гэрчийн оршин байгаа газар, хувийн мэдээлэл зэрэг гэрчийг хамгаалахтай холбоотой мэдээллийг задруулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх	Зохион байгуулалттай хүнд гэмт хэрэг ба цагдаагийн үйл ажиллагааны хууль, 2005
7	Олон улсын эрүүгийн шүүх <sup>65</sup>  Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч нь шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх буюу бусад байдлаар оролцох гэрчийн илчлэх аливаа мэдээллийг задруулахаас сэргийлэх бүх төрлийн арга хэмжээ авах. Үүнд гэрчийн нэр, царай, дуу хоолойг нууцлах, хувиргах, хаалттай хуралдаанаар буюу дүрс бичлэгээр гэрчээс мэдүүлэг авах, мэдүүлгээсээ болж эрсдэлд орох гэрчийг хамгаалах бусад үйл ажиллагаа хамаарна. Гэрчийг тодорхойлох мэдээллийг олон нийтэд буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нууцлах, хувиргахтай холбоотой тусгай арга хэмжээг шүүхийн шийдвэрээр (шүүгчийн захирамжаар) хэрэгжүүлнэ.	Гэрч хамгаалах хөтөлбөр
8	НҮБ-ын Авлигын эсрэг конвенц <sup>66</sup>  Гэрчийг илчлэх мэдээллийн нууцлалыг задруулахаас хамгаалах аюулгүй байдлын журамтай байх. (32 дугаар зүйл. Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах)	НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 2013

Монгол Улсын хувьд “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулиар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл нь нууцалсан зэрэглэлээрээ байнга нууц байхаар зохицуулсан.<sup>67</sup> Энэ хууль Төрийн болон албаны нууцын тухай

organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.15

<sup>64</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.45

<sup>65</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.17

<sup>66</sup> Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008. p.25

<sup>67</sup> Энэ заалтыг “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” 2004 оны хуульд 2013 оны 07 сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн 2004 <http://legalinfo.mn/law/details/497?law-id=497>



хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хүчингүй болсон. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4.п-д зааснаар “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл” нь тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд төрийн нууцад хамааруулах мэдээлэл бөгөөд 17 дугаар зүйлийн 17.4-т зааснаар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцална.

Эндээс харахад гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг задруулах асуудал нь Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлд заасан “Төрийн нууц задруулах” гэмт хэрэгт хамаарч болохоор байгаа бөгөөд тус зүйлийн 1-т зааснаар төрийн нууцыг итгэмжлэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял, 2-т зааснаар энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууц, онц чухал-маш нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял тус тус шийтгэнэ.<sup>68</sup>

## **4.2. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ**

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үүднээс мэдээлэл, мэдээллийн орчин, түүний дэд бүтцэд хууль бусаар нөлөөлөх, өөрчлөх оролдлогоос хамгаалж чадсанаар гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийн бүрэн бүтэн байдал хангагдана.<sup>69</sup> Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 2

<sup>68</sup> Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2015 <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>

<sup>69</sup> Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт Монгол Улсын

дугаар хавсралтаар баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийн бүрэн бүтэн байдал хангахтай холбоотой дараах үйл ажиллагааг төлөвлөжээ. Үүнд:

- Гэрч, хохирогчийн талаар цахим мэдээллийн сан байгуулж ашиглах, нууцлалыг хангах чиглэлээр програм боловсруулж нэвтрүүлэх, үүнтэй холбоотой журам баталж мөрдүүлэх;
- Гадаад улсад хэрэглэж байгаа шинэ техник технологи, тоног төхөөрөмжийг судалж нэвтрүүлэх;
- Дохиолол хамгаалалт, галын аюул, дүрсний хяналт, байршил тогтоогч, цахим цоож, хамгаалах тусгай хувцас, хэрэгслийн жагсаалт гаргаж, ашиглалтын байдал, чанарыг жил бүр үнэлж, сайжруулах арга хэмжээ авах.<sup>70</sup>

Дээр дурдсан үйл ажиллагаа нь бүхэлдээ гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийг аюулгүй хадгалах, шифрлэх, аюулгүй сүлжээ буюу төхөөрөмжид дамжуулах, зайнаас аюулгүй хандахад чиглэсэн байх шаардлагатай юм.<sup>71</sup>

### **4.3. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ**

Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломж бүрдүүлснээр гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.<sup>72</sup> Хууль зүйн сайдын 2014 оны

---

үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 3.6.2.1 <http://legalinfo.mn/annex/details/3350?lawid=6163>

<sup>70</sup> Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 7 дахь хэсэг, түүний 7.2-7.4-т энэ талаар заасан байна.

<sup>71</sup> Manual on Monitoring: Protection of victims, witnesses and other cooperating persons. Office of the United Nations High Commissioner for Human Rights. 2011. p.26 <http://www.ohchr.org/Documents/Publications/Chapter14-56pp.pdf>

<sup>72</sup> Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 3.6.4.1 <http://legalinfo.mn/annex/details/3350?lawid=6163>

07 сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-д зөвхөн гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах талаар зохицуулсан байх бөгөөд мэдээллийн бүрэн бүтэн байдал болон хүртээмжтэй байдлыг хангах талаар зохицуулаагүй үлдээсэн байна.<sup>73</sup> Тодруулбал, тус журамд Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд заасан гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийн бүрэн бүтэн байдал хангахтай холбоотой үйл ажиллагааг орхигдуулсан байна. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23.3.2-т зааснаар гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь гэрч, хохирогчийг мэдээллээр хангах үүрэгтэй тул энэ үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-д тусгах шаардлагатай байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах нь гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг нээлттэй байлгах буюу тийм мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлсэн байхад чиглэнэ. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчимд “Хохирогч нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн болон бусад тусламжийн талаар мэдээлэл авах, тэдгээр үйлчилгээ, тусламжийг хүртэх ёстой” гэж заасан. Энэ нь гэрч, хохирогчийг хамгаалалтад авахдаа хамгаалалтын арга хэмжээ, аюул занал, халдагч этгээдийн болон гэрч, хохирогчийн эрх, үүргийн талаар зохих мэдээллийг тухай бүр бүрэн өгч байх, тийм мэдээлэлтэй танилцах боломж олгож байх шаардлагыг бий болгож байна.

<sup>73</sup> Хууль зүйн сайдын 2014 оны 07 сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаалын хавсралт “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”

## ТАВ. ДҮГНЭЛТ

Гэрч, хохирогчийн мэдүүлэг нь эрүүгийн хэргийн нотлох баримт болох бөгөөд гэрч, хохирогч нь гэмт хэргийг илрүүлэх, нотлох, хянан шийдвэрлэхэд чухал оролцогч юм. Үүнтэй холбоотойгоор гэрч, хохирогчид хууль бусаар нөлөөлөх буюу гэрч, хохирогчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэх, мэдүүлгээс буцаах зорилгоор өөрт нь, ойр дотнын хүнд нь хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулахаар сүрдүүлэх тохиолдол Монгол Улсад гарсаар байна. Түүнчлэн, Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо жил ирэх бүр нэмэгдэж байна.

Тахарын албаны хувьд татан буугдах хүртлээ буюу 2014-2016 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Тахарын албаны тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлсэн бөгөөд 2016 оны дунд үеэс эхлэн Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь нь Тахарын албаны холбогдох нэгжтэй адил бие даан үйл ажиллагаа явуулж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа Тахарын албанаас цагдаагийн байгууллагад шилжсэн нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний тоонд сөргөөр нөлөөлөөгүй бөгөөд Тахарын албанаас хэрэгжүүлж байсан үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаас алдагдуулаагүй байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдсанаас хойш тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх, гэрч, хохирогчийг бодитой, үр дүнтэй хамгаалах агуулга бүхий өөрчлөлтийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар бүлэгт тусгасан байна. Энэ нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээн дэх гэрч, хохирогчийг хамгаалах зохицуулалтаар тогтоосон хэд хэдэн шаардлагад тус хуулийн зохицуулалт нийцсэн байдлаар илэрч байна. Тодруулбал, олон улсын хэм хэмжээгээр тогтоосон дараах шаардлагыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга

болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд баталгаажуулж оруулжээ. Үүнд:

- гэрч, хохирогчийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авах;
- заналхийлэл буй тохиолдолд гэрч, хохирогчийг хамгаалах;
- шүүх, прокурорын зүгээс хохирогч болон гэрчүүдийн хувийн амьдралын аюулгүй байдал, бие махбодын болон сэтгэл санааны сайн сайхан байдал, нэр төр болон хувийн халдашгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээ авах;
- шүүхийн танхим гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүх хуралдааны аливаа хэсгийг хаалттай явуулах буюу нотлох баримтыг цахилгаан буюу өөр тусгай хэрэгслийн тусламжтайгаар гаргаж тавихыг зөвшөөрөх, нотлох баримт буюу мэдээллийг задруулахгүй буюу тэдгээрийн хураангуйг танилцуулах;
- зохих тохиолдолд гэрч, хохирогчийн хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээ авах;
- шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх;
- хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах.

Гэвч гэрч, хохирогчийн гэр бүлийн гишүүнээр хязгаарлалгүйгээр “бусад ойрын хүн”-ийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах зохих арга хэмжээ авах, хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг тараахаас сэргийлэх талаар тусгайлан зохицуулах шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ тодорхой, хэрэгжих боломжтой байхуйц нөхцөлийг бүрэн тусгажээ. Гэвч гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий шүүгч, прокурор, мөрдөгч болон өмгөөлөгчийн зүгээс энэ талын мэдлэг,

ур чадвараа байнга сайжруулах, аюулын эрсдэлийн түвшин тогтоох нэг аргачлал, стандартыг мөрддөг болох нь зүйтэй байна.

Эдгээр болон бусад арга хэмжээг Засгийн газраас 2015 онд баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2016 онд баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-нд тусгаж, төлөвлөсөн байна. Гэвч Монгол Улсын тухайн оны төсвийн тухай хуулийн хавсралтад нэг жилд нийт 70 гэрч, хохирогчийг хамгаалах төсвийг тусгасан байгаа нь хамгаалалт шаардлагатай байж болох 7,306-10,679 гэрч, хохирогчийн тоотой уялдахгүй байна.

Гэрч, хохирогчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь гэрч, хохирогчийг хамгаалах бүхий л үйл ажиллагаанд нэн шаардлагатай, чухал зүйл болжээ. Монгол Улсын өнөөгийн хууль тогтоомжид гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны мэдээллийн нууцыг задруулах зөрчлийг гэмт хэрэгт тооцож, хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан нь олон улсын жишигт нийцсэн байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйлд заасан “Төрийн нууц задруулах” гэмт хэргийн зохицуулалтын дагуу таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял тус тус шийтгэнэ.

Харин гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд ямар мэдээлэл нууцлахыг тодорхой болгох буюу нууцлах мэдээллийн жагсаалтыг нарийвчлан боловсруулах шаардлага тавигдаж байна. Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017.12.28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар баталсан гэрч, хохирогчийг хамгаалах журмаар олон албан тушаалтанд гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээний хяналтын хэрэгтэй бүхэлд нь танилцах эрх олгосон нь хууль тогтоомжийн зорилготой нийцэхгүй төдийгүй гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахад техник тоног төхөөрөмжийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагаа тодорхой байгаа хэдий ч мэдээллийн

бүрэн бүтэн байдал хангахтай холбоотой тусгайлсан сургалтыг эрх бүхий байгууллага, албан хаагчдыг хамруулан тогтмол зохион байгуулахад онцгой анхаарах хэрэгтэй. Энэ хүрээнд Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-д гэрч, хохирогчийг хамгаалах нэгжээс гэрч, хохирогчийг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг тусгах нь зүйтэй байна.

## ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

- Гэрч, хохирогчийн хамгаалалтын хүртээмжийг нэмэгдүүлэх. Үүний тулд Улсын Их Хурлаас тухайн оны төсвийн тухай хуулиар дамжуулан гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн бүтэц, орон тоо, үйл ажиллагаанд зориулсан төсвийг бууруулахгүй байх, бодит хэрэгцээнд тулгуурлан тогтмол нэмэгдүүлэх.
- Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах шийдвэр гаргах шүүгч, прокурор, санал, хүсэлт гаргах мөрдөгч болон өмгөөлөгчийн болон тэрхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгж, ажилтны мэдлэг, ур чадварыг сургалтаар дамжуулан байнга сайжруулах. Үүний тулд Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Цагдаагийн ерөнхий газрын зүгээс гэрч, хохирогчийг үр дүнтэй хамгаалах мэдлэг, ур чадвар олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, дагнасан болон хамтарсан сургалтыг тогтмол зохион байгуулах.
- Гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшин тогтоох нэг аргачлал, стандартыг мөрддөг болох, гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны нэгдсэн мэдээллийн сан бий болгон ашиглах. Үүний тулд Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Монголын Хуульчдын холбоо, Цагдаагийн ерөнхий газрын зүгээс хамтарсан тушаал, шийдвэрээр гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны нэгдсэн аргачлал баталж, мэдээллийн сан бий болгож, тэрхүү тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд тогтмол мониторинг хийх.
- Засгийн газраас 2015 онд баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2016 онд баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-нд тусгасан гэрч, хохирогчийг хамгаалахтай



холбоотой арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнд тогтмол мониторинг хийх.

- Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд ямар мэдээлэл нууцлахыг тодорхой болгох буюу нууцлах мэдээллийн жагсаалтыг нарийвчлан боловсруулах. Үүний тулд Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Монголын Хуульчдын холбоо, Цагдаагийн ерөнхий газрын зүгээс хамтарсан хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах замаар гэрч, хохирогчийн нууцлах мэдээллийн жагсаалтын талаар санал боловсруулж байх.
- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017.12.28-ны өдрийн А/265 дугаар тушаалаар баталсан гэрч, хохирогчийг хамгаалах журамд туссан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэгтэй танилцах албан тушаалтны тоог цөөлөх буюу тийнхүү танилцах хүрээг тодорхой болгох замаар гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн хараат бус байдлыг хангах нь зүйтэй. Тодруулбал, Цагдаагийн төв байгууллагын дарга болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын хувьд тоон мэдээ болон төсвийн зарцуулалт, алба хаагчдын хүртээмжийн түвшинд хяналтын хэрэгтэй танилцах; Гэрч, хохирогчийг хамгаалах нэгжийн болон тасгийн дарга; эрүүгийн цагдаагийн тасгийн даргын хувьд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх алба хаагчдын тоог нэмэгдүүлэх, зардлыг шийдвэрлүүлэх хүрээнд танилцах нь зүйтэй байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд гэрч, хохирогчийн гэр бүлийн гишүүнээр хязгаарлалгүйгээр “бусад ойрын хүн”-ийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалах зохих арга хэмжээ авах, хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг тараахаас сэргийлэх талаар тусгайлан зохицуулах.

## ДОЛОО. НОМ ЗҮЙ

### А. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ЭХ СУРВАЛЖ

#### 1. Эрх зүйн хэм хэмжээ:

1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2012 он, №7
2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2013 он, №30
3. Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга). “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2016 он, №7
4. Цагдаагийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017 он, №8
5. Төрийн болон албаны нууцын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017 он, №11
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (шинэчилсэн найруулга) хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2017 он, №23
7. Монгол Улсын 2014-2019 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2014-2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”
8. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
9. Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, 2 дугаар хавсралт “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”
10. Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралт “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”
11. Цагдаагийн ерөнхий газар. Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (Mongolian National Police Agency Standart Operating Procedure). 4 дэх хэвлэл. Улаанбаатар, 2018 он.
12. Хууль зүйн сайдын 2014.07.02-ны өдрийн А/112 дугаар тушаалын хавсралт “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”

#### 2. Судалгааны тайлан:

13. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, хүйс, насны ангилал, сумаар, жилээр <http://1212.mn/>
14. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо. Улаанбаатар. 2018 он <http://nli.gov.mn/?p=4964>

15. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан. Улаанбаатар. 2018 он <http://nli.gov.mn/?p=4921>
16. Цагдаагийн ерөнхий газар. Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн болон хохирогч иргэн, хуулийн этгээдийн статистик мэдээ. Улаанбаатар. 2019
17. Монгол Улсын нэгдэж орсон олон улсын олон талт гэрээний жагсаалт [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040#1485132523196-a01c7d09-78b5](http://www.mfa.gov.mn/?page_id=29040#1485132523196-a01c7d09-78b5)
18. Шүүхийн шийдвэрийн цахим сан. Зүйл, хэсэг: 21.5.1. <http://new.shuukh.mn/eruanhan>
19. Шүүхийн сургалтын каталог <http://judinstitute.mn/catalog/site/catalog>

### **3. Илтгэл, нийтлэл, ярилцлага:**

20. Г.Баттулга. Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо ба олон улсын чиг хандлага (илтгэл). Улаанбаатар. 2016.06.10. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл.
21. И.Даваажамьян. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зарим асуудал (илтгэл). Улаанбаатар. 2016.06.10. “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийн илтгэлийн эмхэтгэл.
22. “Өнөөдөр” сонин. “Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар: Иргэний амь нас эрүүл мэндийг хамгаалдаг учир хариуцлага маш өндөр”. 2019.02.21 <https://police.gov.mn/a/4261>
23. Ш.Шинэбаяр (ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад). “Гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалж буй өнөөгийн практик, тулгарч буй хүндрэл бэрхшээл” (илтгэл). Улаанбаатар. 2019.06.11

### **Б. ГАДААД ХЭЛ ДЭЭРХ ЭХ СУРВАЛЖ**

24. Anthony Henderson. The CIA Triad: Confidentiality, Integrity, Availability. Panmore Institute. 2015.07
25. Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CAT.aspx>
26. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>

27. Good practices for the protection of witnesses in criminal proceedings involving organized crime, United Nations Office on Drugs and Crime. New York, 2008 <http://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>
28. Manual on Monitoring: Protection of victims, witnesses and other cooperating persons. Office of the United Nations High Commissioner for Human Rights. 2011. <http://www.ohchr.org/Documents/Publications/Chapter14-56pp.pdf>
29. Optional Protocol to the Convention on the Rights of the Child on the involvement of children in armed conflict
30. Rome Statute of the International Criminal Court
31. United Nations Convention against Transnational Organized Crime